

СЭТГЭЦИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛТАЙ ХОРИГДОЛТОЙ АЖИЛЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД



Б.МӨНХБААТАР

Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн
тэнхимийн багш, ахмад



Н.БОЛОРМАА

ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны Сургалт,
нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн Сэтгэл зүйн тусламж
үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, ахмад

Товч утга: Энэхүү илтгэлээр хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь тулгамдсан асуудлуудын нэг болох сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдогчийн онцлог, нөхцөл байдалд хэсэгчилсэн шинжилгээг хийж, цаашид анхаарах асуудлуудын талаар санал дэвшүүлэн, туршлага солилцохыг зорилоо.

Abstract: The aim of this presentation is to segmentally analyze the conditions and characteristics of the inmates who have mental problems, that is one of the urgent issues of the operations of the imprisonment system, discuss and exchange good practices, and recommend future actions.

Түлхүүр үг: Хорих ял эдэлж байгаа хоригдлын сэтгэл зүйн тулгамдсан асуудал, сэтгэл зүйч, нийгэмшүүлэх ажил, оюуны дутуу буюу хомсдол, зан төрхийн өөрчлөлт.

Keywords: Psychological issues of inmates, psychologist, rehabilitation work, mental illness or mental deficiency, behavioral changes.

Манай орны эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн болон эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн салбарт сүүлийн үед томоохон өөрчлөлтүүд хийгдэж, эрүүгийн ялын бодлого нь хатуу чанга, нэг талыг барьж туйлшран хэлбийх бус гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлэгсдэд хандах хүмүүнлэг үзэл санааг дэмжих, хүний эрхийг дээдлэх, хорих ял эдлүүлэх нөхцөлийг

сайжруулах, хоригдлын жам ёсны эрхийг хангахад чиглэн ажиллаж байгаа билээ.

Монгол Улс дахь хорих ял эдлүүлэх ажиллагаа түүхэн хөгжлийнхөө явцад хүртэл хорих ял эдлэгсдийг сурган хүмүүжүүлэх талаар олон талт бодлогыг барьж, хэрэгжүүлэн ажилласаар ирсэн нь хууль, тогтоомж, судалгаа, шинжилгээний тайлан, судлаачдын илтгэлээс харагдаж байдаг.

Хоригдогсдыг хөдөлмөрт сургах, мэргэжил эзэмшүүлэх зэргээр хорих ял эдлэгсдэд зориулсан сургалт, хүмүүжлийн ажил зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж ирсэн билээ.

Эрүүгийн ялын зорилгыг хангах, ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд хорих байгууллагын үндсэн нэг чиг үүрэг нь хоригдолд үзүүлэх нийгмийн ажлын¹ үйлчилгээ юм.

Тэр ч утгаараа өнөөгийн байдлаар хоригдлыг нийгэмшүүлэх, тэдгээрт тулгарсан бэрхшээлийг даван туулахад туслах чиг үүрэг бүхий "Нийгмийн ажилтан", "Сэтгэл зүйч"² -ийн орон тоо батлагдан хорих ангиудад үйл ажиллагаагаа зохион байгуулж байна.

Хорих ангийн сэтгэл зүйч, эмч нар сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолд сэтгэл зүйн үйлчилгээг хүргэж, тэдний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллаж байгаа хэдий ч сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой ажиллах тал дээр анхаарах асуудлууд байсаар байна.

Хорих ял эдлүүлэх явцад хоригдлын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой ажиллах асуудлыг амжилттай зохион байгуулан, хэрэгжүүлсэнээр хоригдолд чиглэсэн эмнэлэг- сэтгэл зүйн үйлчилгээний үр дүнд чухал нөлөө үзүүлнэ гэж бид харж байна. Үүнд:

- Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой ажиллахад анхаарах асуудлыг алба хаагч бүр таньж мэдэж, улмаар өөрийн ажил үүрэгтээ хэрэгжүүлнэ.

¹ 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ын 5.1-д "Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино."

² 2013 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан "СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/" 3.1.19. "сэтгэл зүйч" гэж их, дээд сургуулийг сэтгэл зүйн мэргэжлээр төгссөн мэргэжилтнийг;

- Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдол, түүнд үзүүлэх үйлчилгээний чанар сайжирна.
- Гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн хувьд цагдан хорих газар /төв/, дамжин өнгөрүүлэх анги болон хорих ангид ирэхэд судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулан, орчны өөрчлөлтөд дасан зохицох тал дээр анхаарч тодорхой арга хэмжээг зохион байгуулна.
- Хоригдлыг орчноос хамаарах сэтгэцийн ямар нэг өөрчлөлт, хямралд орохоос урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж өгнө.
- Хоригдлын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр бодитой ажил зохион байгуулагдана.

Хорих ял эдэлж байгаа сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой ажиллаж байгаа өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа анги албад, цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдогсдын сэтгэл зүйг авч үзэхэд 3 хоригдлын 1 нь эрүүл, 2 нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай гэж тодорхойлогдсон байдаг.

Сүүлийн үед сэтгэцийн эмгэг өвчинтэй хоригдлууд ч цөөнгүй хэрэгт холбогдож байна.

Хорих ялаар шийтгэгдсэн хоригдлууд нь сэтгэл зүйн талаас ямар нэг байдлаар сэтгэхүйн, сэтгэл хөдлөлийн буюу зан үйлийн түр зуурын хямралд ихээхэн өртдөг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Иймд хорих ялын хугацааг гүйцэд эдлэх чадваргүй байдалд хүргэдэг Шизофрени өвчний хэлбэрүүд, Эпилепси өвчин, Эпилепсийн тэнэгрэл, даамжрах саа, өтлөлтийн өмнөх солиорол, тархины гэмтлийн шалтгаант Эпилепси, тархины органик өвчний шалтгаант мэдэгдэхүйц тэнэгрэл зэрэг сэтгэцийн өвчнийг анхааралд авах хэрэгтэй байна.

Нэгдсэн эмнэлэгт жилдээ давхардсан тоогоор 3000 орчим хоригдол хэвтэн эмчлүүлдэг. Үүнээс давхардсан тоогоор 220 гаран удаа сэтгэцийн эмгэгтэй болон сэтгэцийн өөрчлөлтөд орсон хоригдол хэвтэн эмчлүүлдэг бол үлдсэн хоригдлуудын 70-80% нь үндсэн өвчнөөс гадна сэтгэцийн тулгамдсан асуудалтай байна.

Хүн амын дунд явуулсан судалгааны материалаас үзэхэд:

Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэг	Өвчтөний эзлэх хувь	
	Хүн амд явуулсан судалгааны материал	
	Сэтгэцийн бүх эмгэгүүдийн дунд эзлэх хувь /%/	Нийт хоригдогсдын дунд эзлэх хувь /%/
Оюуны хомсдол	48.2	7.2
Айдас түгшүүрийн	11.9	0.5
Сэтгэл гутрах эмгэг	1.0	0.15
Тайлбарлаж болмооргүй биеийн зовуурь шаналгаанууд	1.0	0.5
Сэтгэцийн бусад эмгэг	22.2	0.01
Уналт таталт, зан төрхийн өөрчлөлт	16.5	4.5

Дээрх хүснэгтээс үзэхэд нийт хоригдогсдын 7,2 хувь нь оюуны дутуу буюу хомсдолтой, 4,5 хувь нь уналт таталт, зан төрхийн өөрчлөлттэй гэж оношлогдсон байгаа нь цаашид илүү нарийвчлан судлах шаардлагыг бий болгож байна.

Өөрөөр хэлбэл оюуны дутуу буюу хомсын эмнэл зүйн шинж чанараас авч үзвэл сэтгэн бодох чадвар, хэл яриа, сэтгэхүйн үйлдлийн дутуу буюу хомсдолыг судлах шаардлага илүүтэй тулгарч байна.

Тэдний хийж байгаа үйлдэл хөдөлгөөнүүдийн ихэнх нь тухайн үед төрсөн биологийн болон дур хүслийн хэрэгцээг хангахад чиглэгддэг бөгөөд оюуны хомсдолтой хүмүүст хулгай хийх дур, дэмий тэнэх дур, архидах дур, иддэггүй юм идэх дур, хоол хэт их идэх дур, ер бусын замаар бэлгийн дур хүслээ хангах дур, хэвийн хэмжээнээс ихэссэн бэлгийн дур зэрэг илрэл бүхий бие сэтгэцийн дотоод ертөнцийг эзэмдсэн эмгэг дур хүслүүд илэрч байгааг нарийвчлан судлах шаардлагатай байна.

Хорих ял эдэлж байгаа сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой ажиллахад тулгарч байгаа бэрхшээл нэлээдгүй байна. Үүнд:

1.Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой харилцахад алба хаагч, харуул хамгаалалтын ажилтны зүгээс хүндрэл бэрхшээл нэлээдгүй

тулгардаг. Тухайлбал хоригдлын зүгээс биеэ хянах чадвар алдагдах, амиа хорлох үйлдэл хийх, бие эрхтэндээ санаатайгаар гэмтэл учруулах, орчны эд зүйлийг эвдэх бусадтай маргалдах зэрэг үйлдлүүд үүсэх явдал гарч байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс Шизофрени оноштой, хэвтэн эмчилгээ хийлгэж байсан хоригдол тухайн гэмт хэрэгт холбогдох үедээ солиорол илрээгүй тул шүүхээс хэрэг хариуцах чадвартай гэж тогтоогдсон байдаг.

Одоогоор хорих ял эдэлж байгаа бөгөөд зан төлөвийн хувьд үе үе тодорхойгүй шалтгаанаар уурлах, бухимдах, бусадтай харилцааны зөрчил гаргах магадлал өндөртэй, бусдын болон өөрийн бие махбодид гэмтэл учруулах эрсдэлт эмгэг зан төрхийн өөрчлөлт илэрч ямар нэгэн үйлдэл хийж болзошгүй байдаг тул байнгын харуул хамгаалалтын хяналтад байдаг.

Ийм төрлийн өвчлөл нь өвчтөний сэтгэл санааг хэвийн бус болгодог боловч хэрэг хариуцах чадварыг³ алдагдуулдаггүй, мөн түүнчлэн сөргөлдөөнтэй байдалд гадны нөлөөг эсэргүүцэх чадварыг эрс бууруулдаг бөгөөд энэ нь нийгэмд хэрэгтэй зан чанар тогтож төлөвшихөд саад учруулж, өөрийгөө хянах үйл явцыг саармагжуулж, эрх зүйн зөрчил, гэмт хэрэг үйлдэх явдлыг хөнгөвчлөх нэг төрлийн хүчин зүйл болдог тул анхаарахгүй орхиж болохгүй байна.

2. Сэтгэцийн эмгэг, өвчинтэй хоригдол нь хорих байгууллагын нэгдсэн эмнэлгийн хяналтад байдаг бөгөөд эмэн эмчилгээнд тогтмол хамрагдаж, тус ангийн сэтгэл зүйч тодорхой хугацааны давтамжтайгаар уулзалт зохион байгуулан ажиллаж байгаа хэдий ч энэ талын нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаа нь энэ төрлийн сэтгэцийн өвчлөлтэй хоригдолтой ажиллах арга, аргачлал, туршлага бага байгаатай холбоотой байна.

Эмнэлгийн хяналтад байсан ч солиорлын хурц шинж тэмдэг илэрч буй хоригдолд эмэн эмчилгээ хийж засрал сайжралын байдалтай болгосны

³ 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ын 6.3 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт “Сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдолын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй болсныг хэрэг хариуцах чадваргүйд тооцно”; Мөн хуулийн 6.3 дугаар зүйлд “Хэрэг хариуцах чадвар” заалтын 3 дугаар хэсэгт “Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүнд ял оногдуулахгүйгээр энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ” гэж тус тус заасан байдаг.

дараа эмнэл зүйн чиглэлийн сэтгэл зүйн үйлчилгээгээр дэмжих явдал учир дутагдалтай байгаа юм.

3. Хорих ангид шинээр таслагдан ирсэн хоригдол нь өөрийн хийсэн хэрэгтээ гэмшин, сэтгэл санаа хямарч, гэмт хэргийн шокын байдалд орох, цагдан хорих хугацаандаа дасан зохицох эмгэг үүсэж анхаарал төвлөрөлт, тогтворжилт буурсан, өөрийн хяналт суларч, сэтгэл санаа тогтворгүй, уур бухимдал ихсэх, эмх цэгцгүй яриа өгүүлэлтэй болох зэрэг шинжүүд ажиглагдаж улмаар сэтгэцийн эмгэг өвчинтэй болох тохиолдол гардаг.

Гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэний дараа *сэтгэцийн эмгэгтэй* болж өөрийн үйлдлийн бодит шинж чанар, хор уршгийг ухамсарлах, үйлдлээ удирдан жолоодох чадваргүй болсон хүнийг ял эдлэхээс чөлөөлж, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх⁴ талаар зохицуулалт хүртэл байдаг.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Өнөөгийн нийгэмд гэмт хэргийн гаралт, шинж чанар нь улам хэрцгий шинж чанарыг агуулж, нийгмийн хор аюул нь хурдацтай өсөж байгаа нь сэтгэцийн эмгэгийн анхдагч урьдчилан сэргийлэлтийг⁵ идэвхтэй зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

⁴ 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ын 6.13 дугаар зүйлийн “Хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх” заалтын 1 дүгээр хэсэг

Мөн хуулийн 6.13 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт “Шүүх гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэний дараа ял эдлүүлэхэд саад болохуйц өвчнөөр өвчилсөн тохиолдолд ялсныг ял эдлэхээс чөлөөлж болох бөгөөд энэ журмыг хуулиар тогтооно”

⁵ 2013 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан “СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/” 3.1.5. “сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах” гэж хүн амд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулж, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм, сэтгэл зүй, эдийн засгийн цогц арга хэмжээг;

Мөн хуулийн 3.1.6. “сэтгэцийн эмгэгийн анхдагч урьдчилан сэргийлэлт” гэж иргэд, хамт олны дунд сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг тандах, хянах, урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн эрүүл мэнд, нийгмийн цогц арга хэмжээг; 3.1.7. “сэтгэцийн эмгэгийн хоёрдогч урьдчилан сэргийлэлт” гэж өрхийн болон сум, тосгоны эрүүл мэндийн төвд сэтгэц, зан үйлийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх, лавлагаа, тусламжид илгээх, хяналт тавих арга хэмжээг; 3.1.8. “сэтгэцийн эмгэгийн гуравдагч урьдчилан сэргийлэлт” гэж аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага, тусгай мэргэжлийн төвд сэтгэцийн эмгэг даамжран архагшиж, хүний хөдөлмөрийн чадварыг алдуулах, хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэх зорилгоор үзүүлэх эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламжийг;

Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой ажиллахад тулгарч байгаа бэрхшээл, хүндрэлд дүн шинжилгээ хийн дараах чиглэлд анхаарал хандуулан хөгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

Нэг. Хоригдлыг орчин нөхцөлд дасан зохицох хугацаанд тохирох сэтгэл зүйн зөвлөгөөг сэтгэл зүйч нар тогтмол өгч байгаа хэдий ч үр дүнг тооцох, сэтгэцийн эмгэгтэй хүмүүстэй харилцах сэтгэл зүйчийг чадваржуулахад анхаарах;

Хоёр. Тусгайлан энэ төрлийн өвчлөлтэй хоригдолтой ажиллахад эмнэл зүйн сэтгэл зүйчээр мэргэшсэн алба хаагч⁶, сэтгэл зүйн тогтолцоог бий болгох;

Гурав. Сэтгэцийн эмгэгийн анхдагч урьдчилан сэргийлэлтийг тухайн хоригдол, хоригдогсдын дунд сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг тандан судалж тодорхойлон хянах, урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн сэтгэл засалч эмч, сэтгэл зүйч нарын хамтран ажиллах тогтолцоог хөгжүүлэх;

Дөрөв. Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад судалгаа, шинжилгээний ажлыг илүү эрчимжүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн болон мэргэжлийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх зэрэг бодитой ажил хэрэг болгох хэрэгцээ шаардлага бий болсоор байна.

Хоригдолтой ажилладаг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, харуул хамгаалалтын ажилтнуудад мэргэжлийн байгууллагаас сургалт тогтмол давтан авах, хоригдлын сэтгэл зүйн чиглэлээр бусад орны ижил чиг үүрэг бүхий мэргэжилтнээс харилцан туршлага судалж урт богино хугацааны сургалтад хамруулан, цаашид тэдний залгамж халааг бэлтгэж, зорилтот бүлгийн хэрэгцээг ханган ажиллах нь бидний нэн түрүүнд авч хэрэгжүүлэх ажил юм.

⁶ 2013 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан “СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/” 3.1.16. “сэтгэцийн эмч” гэж анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, сэтгэцийн эмчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг дүүргэж, эмчлэх эрхийн зөвшөөрөл авсан хүний их эмчийг; 3.1.17. “эмнэл зүйн сэтгэл зүйч” гэж эмнэл зүйн сэтгэл зүйгээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн сэтгэцийн эмчийг;